94.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.2 дугаар арга хэмжээ-Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх; (АЭХ 18.1.2, ГХЗУСА33-ийн ажлын төлөвлөгөө, ҮАБҮЗ 3.3.2.2)	УССГХ	-Аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд улирал тутамд үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцсон байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, “Шударга байдлын үнэлгээний түвшинг дээшлүүлэх, ЗГ-ын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжилтийг хангах, өргөдөл, гомдол, мэдээллийн агуулга, шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлсэн. Сүхбаатар, Булган, Дархан-Уул, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь аймаг, Сүхбаатар, Хан-Уул дүүргээс ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийв.	2 удаа/100	I- IV	Төсвийн
95.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.3 дугаар арга хэмжээ-Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх; (АХ 2050-5.6.1, 2, АЭХ 18.1.5, ҮАБҮЗ 3.3.2.2, ЕСЗахирамж64-6.1)	УССГХ	-Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө шинэчилсэн байх (төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтан, аж ахуйн нэгжийн ажилтан, оюутан, сурагч, сургагч багш, удирдах албан тушаалтан, иргэн гэх мэт); -Иргэд, зорилтод бүлэг, төрийн албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй, зохион байгуулсан байх; -Өмгөөлөгч, судлаач, аналистуудыг авлигын асуудлаар мэргэшүүлэх; -Сурталчилгааны сувгийг нэмэгдүүлсэн байх;	2025 онд 610 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 41999 хүнийг хамруулав. Сургагч багш бэлтгэх сургалтыг төрийн 50 байгууллагын 117 албан хаагчийг оролцуулан зохион байгуулж, гэрчилгээ олголоо. #110 подкаст, Youtube, “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк, “MGL” радио, МҮОНТ, Малчин, Лайв ТВ, “Авто радио 96.3” радиогоор сурталчилгааг тогтмол хийж байна.	Шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөр-8 Сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй, зохион байгуулсан байх; Сурталчилгааны 4-өөс доошгүй сувгийг нэмэгдүүлсэн байх;	I-II I-IV I-II	Төсвийн
96.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.4 дүгээр арга хэмжээ-Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, авлигад өртөх боломжийг багасгах талаар зөвлөмж хүргүүлэх; (АЭХ 18.1.6, ҮАБҮЗ 3.3.2.2)	УССГХ	-Эрсдэлийг бууруулах, шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн байх;	2025 онд давхардсан тоогоор 79 байгууллагад 85 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн 42 зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, 24 төрийн байгууллага, албан тушаалтанд шаардлага хүргүүлээ.	Зөвлөмжийн чанар дээшилж, хэрэгжилтэд тавих хяналт тогтмолжсон байна.	I-IV	Төсвийн
97.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.5 дугаар арга хэмжээ-Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, ёс зүйн дүрмийн төсөлд санал өгөх; (АХ2050-5.6.7 АЭХ 18.4.2, 6.1.9, ҮАБҮЗ 3.3.2.2)	УССГХ	-АТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/183 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын шаардлага хангасан байх;	Нийг 17 салбарт хамаарах 244 шийдвэр, дүрэм, журмыг хянаж, тухайн дүрэм, журмыг бүхэлд нь хүчингүй болгох, хуульд заасан шаардлага хангуулах саналыг хүргүүлснээс эрх бүхий байгууллагаас 101 захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь хүчингүй болгож, 6 актын холбогдох хэсгийг хүчингүй болгон шийдвэрлэсэн дүнтэй байна. 11	Салбар тус бүрд хамаарах 4-аас доошгүй дүрэм, журам, шийдвэрийг хянаж, үр дүн тооцох	I-IV	Төсвийн

				байгууллагын ёс зүйн дүрмийн төсөлд санал хүргүүлэв.			
98.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.6 дугаар арга хэмжээ-Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг хэрэгжилтийг хангах, сан хөтлөх; (НАН6ХАС3АСЗУСтХ 29.5)	УССГХ	-2026 онд сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчдын мэдээллийг нээлттэй байршуулсан эсэхэд дүн шинжилгээ хийсэн байх; -Нээлттэй байршуулах чиглэлээр шаардлага хүргүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавих; -Шаардлагын хэрэгжилтийн хувь	Нийтийн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн мэдээллийг нээлттэй байршуулсан байдалд хяналт тавьж ажиллав.	3 3 100	I-II, III I, II, III II, IV	Төсвийн
99.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.7 дугаар арга хэмжээ-Мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах шаардлагын мөрөөр ажиллах; (АЭХ 6.6, 6.1.12, ЭХХШтХ 29.6.2)	УССГХ	-Шаардлага, мэдэгдлийн мөрөөр ажилласан үзүүлэлтийн өсөлтийн хувь	ЭХХШтХ-д зааснаар хүргүүлсэн мөрдөгчийн 135 мэдэгдэл, 100 албан бичгийн, үүнээс 76 мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллаж, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, мэдээлэл арга зүйгээр хангах, сургалт хийх зэргээр хамтарч ажиллан, авлигын эсрэг сурталчилгааны материал түгээж ажиллав. 200/72	80.0-90.0	I-IV	Төсвийн
100.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.8 дугаар арга хэмжээ-Авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх; (АЭХ 18.1.6, ҮАБҮБ 3.3.2.2)	УССГХ	18	156 байгууллагын 182 үйл ажиллагаанд тандалт хийж ажиллаж, 40 зөвлөмж, хуулийн хэрэгжилт хангуулах шаардлага 8, санал-2, хүргүүлж, 12 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч, уулзалт зохион байгуулж, 3 байгууллагад сургалт зохион байгуулж, 21 дүрэм журам хянаж үүнээс 1 дүрэм журмыг хүчингүй болгож, гэмт хэргийн талаарх 1 мэдээллийг МШХ-т шилжүүлэв.	5 2 3 2 4 2	I-IV I II II-III III IV	Төсвийн
101.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.9 дүгээр арга хэмжээ-Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний 2015-2025 оны судалгааны дүнд дүн шинжилгээ хийх (АЭХ 18.1.7, ҮАБҮБ 3.3.2.2)	США	-Дүн шинжилгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хамт	“Шударга байдлын үнэлгээ-2025” судалгааг “Бодлогын шийдэл” ХХК-ийн гүйцэтгэсэн. Судалгаанд төрийн 81 байгууллага хамрагдсанаас Мал эмнэлгийн ерөнхий газар, Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Архангай, Дархан-Уул, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээний үзүүлэлт 10.3-1.2 оноогоор буурч, Баянхонгор, Ховд, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын мөн үзүүлэлт 2024 онтой харьцуулбал өөрчлөлтгүй байгаа дүн гарлаа.	1	I-III	Төсвийн
102.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.10 дугаар арга хэмжээ-Сүүлийн 12 сард төрийн албан хаагчтай харилцсан төрийн албан хаагчид авлига	США	-Түүвэр судалгаа, судалгааны тайлан, санал зөвлөмж	Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох 2025 оны	1	I-III	Төсвийн

	өгсөн иргэдийн эзлэх хувийг тодорхойлох түүвэр судалгаа хийх; (АЭХ 18.1.7, TE3B2026XXXYДгЧТХ Үзүүлэлт 11.1.1.3)			судалгааны хүрээнд мэдээлэл цуглуулсан.			
103.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.11 дүгээр арга хэмжээ-Уул уурхайн салбарын авлигын эрсдэлийг үнэлэх аргачлалыг туршиж, үнэлгээ хийх;	США	-Үнэлгээний тайлан, санал зөвлөмж	Уул уурхайн салбарын авлигын эрсдэлийг бодитой үнэлэх, хариу арга хэмжээ авах бодлого, үйл ажиллагааг оновчтой тодорхойлох, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үнэлгээний аргачлал боловсруулах ажлыг “Сэргэлт Консалтинг Групп” ХХК гүйцэтгүүлж, хэлэлцүүлэг хийлээ. Уг хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусган зөвлөмжийг эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэж байна.	1	I-III	Төсвийн
104.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.12 дугаар арга хэмжээ-Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах батлах;	США	-Батлагдсан аргачлал	Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалаар баталсан	1		Төсвийн
105.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.13 дугаар арга хэмжээ-“Шударга ёс” онол, практик, арга зүйн сэтгүүлийг эмхлэн хэвлүүлж, түгээх;	США	-Хэвлэгдсэн сэтгүүл	2	2	II, IV	Төсвийн
106.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.14 дүгээр арга хэмжээ-Авлигатай тэмцэх газарт ирж буй өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд “Аргачилсан заавар” батлан мөрдүүлэх;	США	-Батлагдсан заавар	АТГ-ын даргын 2018 оны А/70 дугаар тушаалаар АТГ-т иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүтгэх, шилжүүлэх, хянан шийдвэрлэх журам”-ыг баталсан.	1	I	Төсвийн
107.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.15 дугаар арга хэмжээ-Худалдан авах ажиллагааны авлигын нөхцөл байдлын судалгааг хийх, үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;	США	-Судалгааны тайлан	2024 онд хийгдсэн. Ажил үргэлжилнэ.	1	II-IV	Төсвийн
108.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.16 дугаар арга хэмжээ-Мөрдөн шалгах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөний талаарх судалгааг зохион байгуулах;	США	Судалгаа, санал, зөвлөмж	2024 онд энэхүү судалгааг эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 45.0 хувьтай байна.	1	I-II	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт № 2.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, ХАСУМ-ийг хянах, төлөвлөгөөт болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
Гүйцэтгэлийн зорилт № 2.2.1. Улсын хэмжээнд мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж арга зүйн удирдлагаар ханган ажиллах, бүртгэл, дүн мэдээг нэгтгэн боловсруулж, олон нийтэд мэдээлэх;							
109.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.1 дүгээр арга хэмжээ-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; (АЭХ 10.6, 11.1, 11.4, 11.5,	ХШДШХ АБХШНА	-Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, мэдээ тайланг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.	Албан тушаалтнуудын 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Нийт 130 байгууллагын 48841 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж, баталгаажуулсан. Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон түүнтэй адилтгах 220 албан тушаалтнаас 204 албан тушаалтан буюу 100 хувь хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна. Нийт мэдүүлгийн хураангуйг цахим хуудсанд	-Нэгдсэн тайлан мэдээ, бүртгэл -УИХ-ын Хууль зүйн Байнгын хороо, ҮСХ-д хүргүүлсэн тайлан	I II-III	Төсвийн

	НАН6ХАС3АС3УСТХ 24.1.1, 24.3, УАБҮЗ 3.3.2.2, ТЕЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.2.1)			нээлттэй байршуулж ил тод мэдээлсэн. Хуулийн хугацаанд ҮСХ-д мэдээг хүргүүлж, захиргааны албан ёсны статистикийг бүрдүүлэн, тайланг УИХ-ын ХЗБХороонд хүргүүлсэн.			
110.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.2 дугаар арга хэмжээ-ХАСХОМ-ийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт бууралтад дүн шинжилгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх; (АХ2050ҮА-5.6.8, УАБҮЗ 3.3.2.2, ТЕЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.2.1, АЭХ 13.5, 13.6, НАН6ХАС3АС3УСТХ 26.3, 26.5, ТИМ2024-4)	ХШДШХ	-Эрсдэл тооцох аргачлалд өөрчлөлт оруулсан байна. -Тусгай зөвшөөрөл олгодог чиг үүрэг бүхий байгууллагын албан тушаалтныг хяналт шалгалтад хамруулсан байна. -Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. -Татварын байгууллагатай хамтран ажилласан байна.	2025 онд нийт 125 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах аас шийдвэрлэлт 88,0 хувьтай байна. Хяналт шалгалтаар 25 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт холбогдох гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгуулахаар тус газрын харьяалах хэлтэст шилжүүлснээс 9 албан тушаалтанд холбогдох үйлдэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3 албан тушаалтныг яллагдагчаар татаж, хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар НПГ-т хүргүүлсэн байна. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй 7 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг ТЕГ-т шилжүүлснээр шалгалтаар 4,7 тэрбум төгрөгийн татварын зөрчилд 590,9 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна.	1 1 1 1	II I-II I-IV I-IV	Төсвийн
111.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.3 дугаар арга хэмжээ-Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх (АЭХ 13.1, УИХ, ХЗБХ2024, 05 дугаар тогтоол)	ХШДШХ	-Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	Эрчим хүчний яам, Боловсролын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагууд (Хөгжлийн банк, Шинжлэх ухааны академи, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв, Үндэсний хөгжлийн хүрээлэн), “ДЦС-4” ТӨХК, “Барилгын хөгжлийн төв” УТҮГ-т бүрдүүлэлтийн хяналт шалгалт хийж, мэдүүлэг гаргах албан хаагчдын хүрээг зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	5	III-IV	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт № 2.2.2 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүн шинжилгээ хийх;							
112	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2.1 дүгээр арга хэмжээ-Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, мэдэгдэх; (ТЕЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.2.1, НАН6ХАС3АС3УСТХ 23.5)	ХШДШХ	-Шийдвэрлэлтийн хувь	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн өмнөх оны үлдэгдэл 411, 2025 оны 19203, нийт 19614 этгээдийн ХАСУМ-ийг хянан шалгах аас 19287 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэсэн. ажиллагаанд 327 мэдүүлэг хянагдаж байна. Хянасан урьдчилсан мэдүүлгийн тоо 2775 нэгжээр буюу 16.8 хувиар өссөн. Шийдвэрлэлт 98.3 хувьтай.	98.5	I-IV	Төсвийн

113.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.2.2 дугаар арга хэмжээ-Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан, хүргүүлсэн мэдэгдэлд хяналт шинжилгээ хийх; (НАН6ХАС3АСЗУСтХ 23.5, 29.2.2)	ХШДШХ	-Дүн шинжилгээ, дүгнэлт, санал -Санал үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээ/-Хариуцлага хүлээлгэсэн томилох эрх бүхий этгээдийн тоо	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс 2019 оноос 2025 онд мэдүүлсэн мэдүүлгийн, үүнээс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд мэдүүлсэн (ХАСУМ)-ийн илт ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон нэр дэвшигчийн, шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон этгээдийн судалгаанд дүн шинжилгээ хийж, дүнг үйл ажиллагаанд ашиглаж байна. Хуульд зааснаар хянуулаагүй томилсон этгээдэд хариуцлага тооцуулахаар шаардлага хүргүүлснээс 37 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.	1 Тухай бүр	II III- IV	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт № 2.2.3 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; (хориглолт, хязгаарлалт, бусад)							
114.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.3.1 дүгээр арга хэмжээ-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх талаар тогтмол сургалт зохион байгуулах; (ТЕЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.4.1)	ХШДШХ	-Цахим системд сургалт/видео-ын материалыг байршуулж, хэрэглэх боломжийг бүрдүүлсэн байх;	Нийт 37 удаагийн удаагийн сургалт (цахим, танхимаар)-д нийт давхардсан тоогоор 9747 хүнийг, үүнээс 4522 ЭБАТ, 5225 мэдүүлэг гаргагчийг хамруулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, сургалтад хамруулсан албан тушаалтны тоо 44,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	20	I-II I-IV	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт № 2.2. Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх;							
115.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.4.1 дүгээр арга хэмжээ-Төрийн захиргааны болон орон нутгийн салбар, нэгжийн мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах; (УИХ,ХЗБХ 2024, 05 дугаар тогтоол, ТЕЗБ2026ХХХҮДтЧТХҮзүүлэлт 1.1.4.1)	ХШДШХ	-Цахим системд сургалт/видео-ын материалыг байршуулж, хэрэглэх боломжийг бүрдүүлсэн байх; -Сургалт зохион байгуулах; -Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж хүргүүлсэн байх;	Мэдүүлгийн бүрдүүлэлт /mediuleg.iaac.mn/-ийн болон хяналт шалгалт /iad.iaac.mn/-ын систем сургалт, арга зүйн төлөвийг үүсгэж, үйл ажиллагаанд тогтмол ашиглах нөхцөлийг бүрдүүллээ. Нийт 37 удаагийн удаагийн сургалт (цахим, танхимаар)-д нийт давхардсан тоогоор 9747 хүнийг сургалтад хамруулснаас 4522 ЭБАТ-ыг сургасныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 78.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мэдээлэл, арга зүйгээр хангаж, зөвлөгөө өгөх ажлыг тасралтгүй гүйцэтгэж байна.	5 2/4600 1	I-II I-IV I, II, III	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт № 2.2.5 Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх;							
116.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.5.1 дүгээр арга хэмжээ-Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч хянан шалгах, үр дүнг тооцох; (ТЕЗБ2026ХХХҮДтЧТХҮзүүлэлт 11.1.4.1, АЭХ 9, 13.5, 18.4.6, НАН6ХАС3АСЗУСХ 26.4, 26.5)	ХШДШХ	-Шийдвэрлэлтийн хувь, өсөлт	2025 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 942 (өмнөх оны үлдэгдэл 64), нийт 1006 гомдол, мэдээллийг хянан шалгах аас тайлант хугацаанд 945 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн, шийдвэрлэлт 94.0 хувьтай байна. Нийт гомдол,	95.0	I-IV	-

				мэдээллийн 95.3 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн байна.			
Гүйцэтгэлийн зорилт № 2.3 Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах							
117.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.1 дүгээр арга хэмжээ-Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэн шалгаж, шийдвэрлэх; (Алсын хараа 2050-5.6.6)	МШХ	-Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн өсөлтийн хувь	2025 онд гэмт хэргийн талаарх 1322 гомдол, мэдээллийг шалгасан. Шийдвэрлэлт 97.5 хувьтай байна.	98.0	I-IV	Төсвийн
118.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.2 дугаар арга хэмжээ-Мөрдөн шалгах ажиллагааг хуулийн дагуу шуурхай явуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт хэргийн шийдвэрлэлт өсгөх; (Алсын хараа 2050-5.6.6, УАБҮЗ 3.3.2.2)	МШХ	-Хэргийн шийдвэрлэлтийн хувь	2025 онд хуульд заасан харьяаллын 2259 үйлдэлтэй, 1369 холбогдогчтой, 1911 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.6 хувиар өссөн байна. /2024 онд 1863 хэрэг шалгасан/ Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 57.0 хувьтай байна	60.0	I-IV	Төсвийн
119.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.3 дугаар арга хэмжээ-Мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, нотлох баримт дутуу, хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлээгүй гэх үндэслэлээр прокурор, шүүхээс эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар буцсан хэрэг өмнөх оны мөн үеэс 5 хувиар бууруулах; (Алсын хараа 2050-5.6.6)	МШХ I-IV	-Шүүх, прокуророос буцсан хэргийн бууралтын эзлэх хувь	2025 онд шүүх, прокуророос давхардсан тоогоор 421 хэрэг буцсан. Үүнээс 62 нь шүүхээс, 359 хэрэг прокуророос буцсан байна. Өмнөх онтой харьцуулахад прокурорын буцалт 41 хэргээр буюу 10,9 хувиар буурсан, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэг 14 хэргээр буюу 29,2 хувиар өссөн. Нийт буцалт 3 хэргээр буюу 0,7 хувиар өссөн үзүүлэлттэй буюу урьд оны мөн үетэй ижил байна.	5.0	I-IV	Төсвийн
120.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.4 дүгээр арга хэмжээ-Шүүхэд шилжүүлсэн, шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх; (Алсын хараа 2050-5.6.6, УАБҮЗ 3.3.2.2)	МШХ	-Шүүхэд шилжүүлсэн болон шийдвэрлэгдсэн хэргийн өсөлтийн хувь	Харьяаллын 1837 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 387 буюу 20.8 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн. Харьяаллын 1911 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 367 буюу 19.2 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг 12.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	20.0	I-IV	Төсвийн
121.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.5 дугаар арга хэмжээ-Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, олсон орлого, нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгийг битүүмжлэн хамгаалах арга хэмжээг авч хохирол нөхөн төлүүлэлтийг урьд оны мөн	МШХ	-Мөрдөн байцаалтын хэрэгт бүрт учирсан хохирлыг бүрэн тогтоосон байх -Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээг 5.0 хувиар ахиулсан байна.	2025 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 674,7 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 163,1 тэрбум, төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц,	100 5.0	I-IV	Төсвийн

	үеэс нэмэгдүүлэх; (Алсын хараа 2050-5.6.6, УАБҮЗ 3.3.2.2)			автомашин, тоног төхөөрөмж зэрэг 84,6 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна..			
122.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.3.1.6 дугаар арга хэмжээ-Гэмт хэрэг, зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар Авлигын эсрэг хууль, Иргэний хууль, Прокурорын тухай хуульд заасан зохион байгуулалтын арга хэмжээ авах; (АЭХ 34.1, Прокурорын тухай хууль 5.1, 20.1, ИХШХШтХ 31.1)	Тамгын хэлтэс МШХ ХШДШХ	-Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульд зааснаар хэрэгжүүлсэн ажиллагаа, үр дүн	2025 онд төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан нь тогтоогдсон 2 этгээдээс нийт 1 тэрбум 110 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр холбогдох хуульд заасан ажиллагааг хийсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн улмаас учруулсан 735,135,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх, мөн шийдвэр гаргахдаа бусдад давуу байдал олгосон, ашиг сонирхлын зөрчилтэй, мөн ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдлыг бий болгосон 2 шийдвэрийг хүчингүй болгуулаа.	Төр, нийтийн ашиг сонирхолд учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн байдал Хүчингүй болгуулсан эрхийн актын тоо	I-IV	Төсвийн
Гурав. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт							
3.1 Нийтлэг чиг үүрэг-Төрийн захиргааны удирдлага							
Гүйцэтгэлийн зорилт №3.1.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх							
123.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1 дүгээр арга хэмжээ-Байгууллагын стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах (ТатХ53 дугаар зүйл)	Тамгын хэлтэс	-АТГ-ын стратеги төлөвлөгөө -Хэрэгжилтийг зохион байгуулсан байх;	Байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	1 Тухайн жилийн хэрэгжилтийн хувь	I I-IV	Төсвийн
124.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.2 дугаар арга хэмжээ-Хүний нөөцийн болон сургалтын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах (UNCACЗөвлөмж-1088 ТИМ2024-4)	Тамгын хэлтэс	-Хэрэгжилтийн хувь	2021 онд Хүний нөөцийн төлөвлөлтийн баримт бичиг, сургалтын хөтөлбөр, албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлагдсан бөгөөд хэрэгжилтийг хангах ажлыг тасралтгүй зохин байгуулж байна.	100	I I-IV	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт №3.1.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх							
125.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.1 дүгээр арга хэмжээ-Байгууллагын архивыг бүрдүүлэх; (ААХХтХ)	Тамгын хэлтэс	-2025 үүсч хөтлөгдсөн баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авсан тоо, гүйцэтгэлийн хувь -2026 оны ХХНЖ-ыг боловсруулж батлуулсан байх; -ББНШ хуралдаан -Тухайн жилд Төв архивт шилжүүлсэн баримтын тоо	Байгууллагын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн баталж, Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар байгууллагад 2009-2019 онд, Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд 2002-2014 онд үүсч хөтлөгдсөн нийт 955 хадгаламжийн нэгжийг устгах асуудлыг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангалаа.	100 1 3 Батлагдсан жагсаалтаар	I I I, III I-IV	Төсвийн

				Үүсч хөтлөгдсөн баримтуудаар цахим сан үүсгэж байна.			
126.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.2 дугаар арга хэмжээ-Албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдөх, “Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх хадгалах журам”-ын хэрэгжилтийг хангах	Тамгын хэлтэс	-Алба хэрэг хөтлөлтийн хууль, журмын хэрэгжилтийг хангах; -Хэвлэмэл хуудасны бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлсөн байх; -Хэвлэмэл хуудсыг зохих журмын дагуу хадгалж, зарцуулалт, устгалын бүртгэлийг хөтөлсөн байх; -Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг зохих журмын дагуу хагас, бүтэн жилээр тайлагнаж, санхүүтэй тооцоо нийлсэн байх;	2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай 280 гэрээ байгуулж, тодорхой ажил үйлчилгээ авсан байна. Байгууллагын хэмжээнд А тушаал 100, Б тушаал 137 батлагдсан байна. Бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 16278 албан бичиг хүлээн авч, бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 21236 албан бичиг илгээж, орон нутгийн шууданд болон бусад албан байгууллагад давхардсан тоогоор 27765 бичиг баримт хүргэсэн үзүүлэлттэй байна. Зөрчил дутагдал гараагүй болно.	-Хэвлэмэл хуудасны бүртгэл, тооцоо, захиалга зохих журмын дагуу хийгдсэн байна. -Зөрчил дутагдал гараагүй байх;	I-IV	Төсвийн
127.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.3 дугаар арга хэмжээ-Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг зохих журмын дагуу хүлээн авч, бүртгэл, шийдвэрлэлтэд байнгын хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах; АЭХ, ИТБАТГӨГХШтХ, ТЭЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.3.1)	США Бусад хэлтэс, албад	-Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хувь -Хуулийн /анхны/ хугацаанд шийдвэрлэлтийн хувийн өсөлт -Дүн шинжилгээ хийсэн давтамж, дүгнэлт санал	Байгууллагын хэмжээнд 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 3034 гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэст 1766 буюу 58,2 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 949 буюу 31,3 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэст 164 буюу 5,4 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 95 буюу 3,1 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд 58 буюу 1,9 хувь нь хуваарилагдан хянан шалгагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 88 нэгжээр буюу 3,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	98.0 50 хувь 4	I-IV I-IV Улирал бүр	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт №3.1.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;							
128.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.1 дүгээр арга хэмжээ-ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээ (ACN) байгууллагаас зохион байгуулах Истанбулын арга хэмжээний төлөвлөгөө (IAP)-ны тавдугаар мониторингийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах; (ТЭЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.1.5)	УССГХ Бусад хэлтэс, албад	-Сүлжээний Бүгд хурлаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байх;	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээний бүгд хуралд танилцуулагдсан Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн тайланг хүлээн авлаа.	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	I-IV	Төсвийн
129.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.2 дугаар арга хэмжээ-Хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх, хамтын ажиллагаатай байгууллагатай бүх чиглэлээр хамтран ажиллах;	Тамгын хэлтэс Бусад	-БНХАУ-ын Үндэсний хяналтын хороо, БНУзбекстанУ-ын Авлигатай тэмцэх агентлагтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах саналыг илэрхийлэх, холбогдох арга хэмжээг авах;	2025 онд Малайз улсын Авлигатай тэмцэх хороо, Тайландын Хаант Улсын Авлигатай тэмцэх үндэсний хороотой Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.	-Гүйцэтгэл хангагдсан байх;	I-IV	Төсвийн
130.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.4 дүгээр арга хэмжээ-Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-аас хэрэгжүүлэхээр	США	-Санамж бичиг байгуулж, төлөвлөгөөний дагуу холбогдох ага хэмжээ хэрэгжсэн байх;	2025 оны 12 дугаар сард Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-аас хэрэгжүүлэхээр	100	I-IV	Төслийн

	төлөвлөсөн “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал /2024–2027/” хоёрдугаар хөтөлбөрт хамтран ажиллах;	Бусад хэлтэс, албад		төлөвлөсөн “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал /2024–2027/” хоёрдугаар хөтөлбөрт хамтран ажиллахаар санал хүргүүлсэн.			
Гүйцэтгэлийн зорилт №3.1.4. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах ¹ ;							
“Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;							
131.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.1 дүгээр арга хэмжээ-Сургалт зохион байгуулах (сэтгүүлчид болон албан хаагчдад); (ТЕЗБ2026ХХХҮДтЧТХ Үзүүлэлт 11.1.4.3)	Тамгын хэлтэс	-Сургалт зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө -Сургалт зохион байгуулсан тоо	-Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, холбогдох бусад асуудлаар мэдээ, мэдээлэл солилцох, харилцан туршлага судлах, хамтран ажиллах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын 25 сэтгүүлчийг хамруулан сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулсан.	1 2	I I,IV	Төсвийн
132.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.2 дугаар арга хэмжээ-Албан хаагчдыг оролцуулан ажлын байранд нь ярилцлага хийх (ажлын нэг өдөр) г.м	Тамгын хэлтэс	-Байгууллагын цахим хуудсаар дамжуулан сошиалд түгээх /байгууллагын фейсбүүк, твиттер, вэб хуудас/ болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын контентод оролцуулах /gogo.mn “Маргааш ажилтай”, asu.mn “My career”, ubn.mn “Гол дүр” г.м/ ажлыг зохион байгуулах;	“Өдрийн сонин”-д “Авлигын эсрэг залуусын дуу хоолой” тогтмол булан үүсгэж, цуврал 16 ярилцлага (speak out)-ыг бэлтгэж нийтлүүлэв. “Иргэний мэдээ”, “Маргааш ажилтай”, “Миний ажлын ширээ”, “Өглөөний зочин”, “My career” зэрэг 12 удаагийн контентод оролцож, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлж ярилцлага өгөв.	6	I-IV	Төсвийн
133.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.3 дугаар арга хэмжээ-Зангиагүй уулзалт, өглөөний цай г.м байгууллагын үйл ажиллагааг таниулах, сурталчлахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах;	Тамгын хэлтэс	-Уулзалт зохион байгуулсан тоо	АТҮХ-ийг сурталчлах, цаашид хамтран ажиллах чиглэлээр www.asu.mn, www.zindaa.mn, TV8 телевиз, “Өглөөний сонин”, “Welcome to Mongolia” сэтгүүлийн редакцын сэтгүүлчидтэй ажил хэрэгч уулзалтыг зохион байгуулж, авлигын эсрэг хууль тогтоомж, АТГ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, цаахдын хамтын ажиллагааны талаар ярилцлаа.	3	I-III	Төсвийн
134.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.4 дүгээр арга хэмжээ-Байгууллагын албан ёсны цахим хуудсанд мэдээлэл тавих; (НТИТБтХууль 8 дугаар зүйл)	Тамгын хэлтэс Ажлын хэсэг	-Мэдээ, мэдээллийн тоо	-Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд нийт 379 мэдээ, мэдээлэл байршуулсан.	400	I-IV	Төсвийн
135.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.5 дугаар арга хэмжээ-“Авлигыг сурвалжлах нь” гарын авлага боловсруулах, хэвлүүлэх түгээх;	Тамгын хэлтэс	-Гарын авлага	-	1	II-III	Төсвийн

¹ ХМОНХБодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тусгав.

136.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.6 дугаар арга хэмжээ-“Найзын яриа” видео контент, жүжигчилсэн тоглолт хэлбэрээр бэлтгэн, түгээх;	Тамгын хэлтэс	-Бүтээсэн видео контент, жүжигчилсэн тоглолт	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар Зөвлөлтэй хамтран 2025 оноос ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийнханд зориулсан “Найзын яриа” номыг хэвлүүлэв. Уг номд дурдсан шударга ёсны 10 өгүүллэгийг видео контент, жүжигчилсэн тоглолт хэлбэрээр бэлтгэн, түгээхээр “Насан туршийн боловсролын төв”, “Хонх.мн” агентлагтай хамтран ажиллаж байгаа.	10	I-III	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт №3.2 Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;							
137.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.1 дүгээр арга хэмжээ-Үйл ажиллагааг хөнгөвчлөх програм хангамж боловсруулах, программ хангамжид хөгжүүлэлт хийх;	АБХШНА Холбогдох хэлтэс, албад	-Хөгжүүлэлт хийсэн байх	Смарт оффис систем нь ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдол, гэмт хэргийн бүртгэл, хүний нөөц, эд мөрийн баримт, мэдүүлгийн өрөөний бүртгэл, сахилгын мэдээ, албаны шалгалт явуулсан мэдээ, албан томилолтын мэдээ, ажлын цаг бүртгэл, чөлөө олголт, амралтын өдөр ажиллах хүсэлт, гадуур ажлын хүсэлт, албан томилолтын зааварчилгаа, гадаад улсад зорчих зөвшөөрөл, эмнэлгийн магадалгаа зэрэг 20 гаруй модулийг агуулсан цогт систем болсон.	Ажилд орох хүсэлт, шагналын тодорхойлолт, тээврийн хэрэгслийн ашиглалт, түлхүүрийн бүртгэл зэрэг модулийг хөгжүүлсэн байх;	I-IV	Төсвийн
138.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.2.1.2 дугаар арга хэмжээ-Тээврийн хэрэгслийн ашиглалтын бүртгэл, мэдээллийг цахимд шилжүүлж, Smart office програмтай уялдуулах;	АБХШНА ААА	-Бүртгэл бүрэн цахимд шилжсэн байх;	-	1	I-III	Төсвийн
Гүйцэтгэлийн зорилт №3.3 Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах;							
139.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.3.1.1 дүгээр арга хэмжээ-Харъяа нэгжүүдэд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалт хийж, үр дүнг тооцох;	АБХШНА	-Хяналт шалгалтын төлөвлөгөө -Төлөвлөгөөний хэрэгжилт	Албан хаагчийн сахилгын зөрчлийн талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд ил болсон мэдээлэл, хэлтэс, албад болон албан хаагч өөрөө илрүүлсэн үйлдэл, эс үйлдэхгүйг хянан шалгаж, зөрчлийн шинж байдал, хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тогтоох ажиллагааг явуулж шийдвэрлэлээ. Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, албан хаагчдыг сахилгын зөрчил, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах талаар 9 удаа чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.	1 100	I I-IV	Төсвийн

			-Даатгалын нөхөн төлбөрийн нөхөн олголт	хариуцлагын даатгалын гэрээг байгуулж, гэнэтийн ослын даатгалын болон хөдөлмөрийн чадвараа түр алдсаны даатгалын нөхөн төлбөрийг албан хаагчдад олгуулах ажлыг зохион байгууллаа. “Практикал даатгал” ХХК-тай авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.			
144.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.5.1.4 дүгээр арга хэмжээ-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах 2026 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах; (ТБНӨХБАҮХАтХ)	Тамгын хэлтэс	2026 онд Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлал боловсруулж, үнэлгээ хийх /36.5/, Боловсролын салбар дахь авлигын эрсдэлийг үнэлэх аргачлал боловсруулж, үнэлгээ хийх /36.5/ Б, В байрны дээврийн их засварын ажил гүйцэтгэхэд /239.5/, Техник, тоног төхөөрөмж шинээр худалдан авахад /729.2/, дотоод хэрэгцээнд шаардлагатай шатахуун нийлүүлэх /35.8/ төгрөгийн бараа ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар болон нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авахаар төлөвлөсөн.	ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний нийт 2.342,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, “Авлигатай тэмцэх газрын “Б” байрны гадна фасад болон хэсэгчилсэн их засварын ажил, Авлигатай тэмцэх газрын Б байрны цахилгаан шат нийлүүлэх, шинэчлэх, Авлигатай тэмцэх газарт тээврийн хэрэгсэл нийлүүлэх гэсэн нийт 3 гэрээний гүйцэтгэлд 2355,0 сая төгрөгийг олгож, хэрэгжилтийг https://pimis.publicinvestment.gov.mn цахим системээр нийтэд ил тод мэдээлж, худалдан авах ажиллагааны мэдээ, тайланг сар бүр төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх зэргээр хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	Худалдан авах ажиллагааны үр дүн	I-III	1,077.5
145.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.5.1.5 дугаар арга хэмжээ-Байгууллагаас чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах; (АНтХууль 12 дугаар зүйл)	Тамгын хэлтэс	-Шинэчлэгдсэн судалгаа -Хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт	Ахмад настны ухай хуульд заасан тусламж, дэмжлэгийг тухай бүр үзүүлсэн. Ахмад настны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг баталсан.	1 100	I I-IV	Ахмадын сангийн мөнгөн хөрөнгө
146.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.5.1.6 дугаар арга хэмжээ-Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тогтмол үзүүлэх; (ЭМтХ 44 дүгээр зүйл)	Аж ахуйн алба	-Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт хамруулсан хувь	АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 195 албан хаагчийг буюу 96.4 хувийг хамруулж, дунг үндэслэн албан хаагчдын дархлааг дэмжих, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран, өдрийн эмчилгээг бүрэн хамруулсан нь үр дүнтэй ажил боллоо. Эмчийн кабинетаар давхардсан тоогоор 2112 албан хаагчид эрүүл мэндийн анхан шатны тусламж, эмчилгээ үзүүлсэн.	100	I, IV	Төсвийн
147.	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.5.1.7 дугаар арга хэмжээ-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (ХАБЭАтХ, 27.2)	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах орон тооны бус Зөвлөл	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан. Зөрчил дутагдал гараагүй.	100	I-IV	Төсвийн